



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 9 сарын 09 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот


Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.1.2 дахь заалт, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Татварын ерөнхий газрын 2021 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 01/2021 тоот тодорхойлолтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний Зориг Ногоон Намаас Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын нөхөн сонгуульд нэр дэвшүүлсэн Алтанхуягийн Бархүү нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.2-т заасан татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх шаардлагыг хангаагүй байх тул нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000185